

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төлөвлөгөө гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандарт
НББББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААН	Аж ахуйн нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭС МЕТАН ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.АМАР
ТАНАА

2020.03.13 № 06/870
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Метан ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэс Метан ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн цэвэр хөрөнгө/өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэс Метан ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Эрдэнэс Метан ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Эрдэнэс Метан ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Д.Амар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.

Эрдэнэс Метан ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Эрдэнэс Метан ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгыг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 13-наас 2020 оны 3 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, ҮАГ-ын захиалгаар “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Сарантуяа, аудиторовын туслах М.Нямбаяр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэс Метан ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгыг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 01/16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрдэнэс Метан ХХК нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Монгол орны хэмжээнд метан хийг олборлож ашигласнаар байгаль орчинд ээлтэй экологийн цэвэр эрчим хүчний эх үүсвэр бий болгоход оршино" гэж тодорхойлсон.

Эрдэнэс Метан ХХК-ийн дүрэмд үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Уламжлалт болон уламжлалт бус газрын тосны хайгуул судалгаа хийх
- Газрын тостой холбоотой үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт татах
- Үндсэн үйл ажиллагаатай холбоотой тээвэрлэлт
- Газрын тосны хайгуул, судалгаа, тээвэрлэлт болон бусад үйл ажиллагаатай холбоотой бизнесийн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Эрдэнэс Метан ХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрдэнэс Метан ХХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа "Даймонд" нэртэй программ хангамж ашиглаж байна.

Эрдэнэс Метан ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 444.0 сая төгрөгөөс тооцон 6.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатны материаллаг байдалтай ижил тооцов.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэс Метан ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 92.5 сая төгрөгөөр буюу 145.8 хувиар өссөн байна. Энэ нь Метан хий олборлох болон ашиглах зорилготой хамтарсан компани байгуулж 105.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12.9	0.8	(12.1)
Авлага	0.7	2.0	1.3
Урьдчилгаа	0.0	1.0	1.0
Бараа материал	1.1	0.0	(1.1)
Үндсэн хөрөнгө	14.8	12.4	(2.4)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	34.0	139.9	105.9
Нийт хөрөнгө	63.4	155.9	92.5
Өр төлбөр	742.0	1281.5	539.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	(678.6)	(1125.5)	(446.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	63.4	155.9	92.5

Авлага дансны үлдэгдэл өссөн нь 2019 онд ажилтнуудад илүү олгосон цалинг суутган авахаар тооцон авлага үүсгэсэн бөгөөд 2020 оны 01-р сарын цалингаас суутгагдсан байна.

Нийт өр төлбөрийн хэмжээ 72.7 хувь буюу 539.5 сая төгрөгөөр өссөн нь Эрдэнэс Метан ХХК-ийн 2019 оны үйл ажиллагааны санхүүжилтийг зээл хэлбэрээр Эрдэнэс Монгол ХХК-аас санхүүжүүлсэн, мөн хамтарсан компанийн Эрдэнэс Метан ХХК-ийн эзэмших 40 хувийн хувьцаа буюу 40.0 мянган ам долларыг Жейд Метан ХХК-аас зээлж авсантай холбоотой байна.

2.9. Төлөвлөгөө гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Компанийн үйл ажиллагааг толгой компаниас зээл хэлбэрээр санхүүжүүлдэг бөгөөд Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 58 дугаар тогтоолоор Эрдэнэс Метан ХХК-ийн 2019 оны төсвийн төлөвлөгөөг баталсан байна.

Хүснэгт 2. Орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Толгой компанийн санхүүжилт	310.6	297.3	(13.3)	91.4
Хүүний орлого	-	0.5	0.5	-
Нийт дүн	310.6	297.8	(12.8)	95.9

Нийт 310.6 сая төгрөгийн санхүүжилтийн орлого төлөвлөгдсөнөөс 297.3 сая төгрөгийн санхүүжилт хийж 13.3 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн нь харилцах дансанд урд оны санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл байсантай холбоотой байна.

2019 оны эцэст батлагдсан төсвийн гүйцэтгэл дараахь байдалтай байна:

Хүснэгт 3. Зардал

/сая төгрөг/

№	Зардлын зүйл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны зардал	304.8	297.7	7.0	97.9
1	Үндсэн цалин	137.9	137.2	0.6	99.6
2	ЭМНД Шимтгэл	18.6	16.9	1.7	90.9
3	Бичиг хэрэг	2.9	2.9	-	100.0
4	Шатахуун, шатах тослох материал	3.6	3.6	-	99.9
5	Машин түрээс /албан томилолтоор ажиллах/	5.8	5.7	0.1	99.7
6	Гадаад албан томилолт	29.6	29.4	0.2	99.3
7	Дотоод албан томилолт	18.6	14.1	4.4	76.1
8	Шуудан, харилцаа холбоо, илгээмж явуулах	3.5	3.5	-	98.9
9	Хэвлэл захиалга	0.5	0.5	-	100.0
10	Хангамжийн материал	2.8	2.8	-	100.0
11	Сургалтын зардал	1.5	1.5	-	100.0
12	Мэдээлэл, зар сурталчилгаа	1.5	1.5	-	100.0
13	Гэрээт ажлын хөлс	15.0	15.0	-	100.0
14	Хурал зөвлөгөөн, уулзалтын зардал	6.0	6.0	-	100.0
15	Түрээсийн зардал	52.0	52.0	-	100.0
16	Гаражийн түрээс	1.8	1.8	-	100.0
17	Бусад зардал	3.3	3.2	0.1	98.2
2	Хөрөнгө оруулалтын зардал	5.8	5.5	0.4	93.0
1	Тавилга, эд хогшил			-	
2	Компьютерын дагалдах хэрэгсэл	3.3	3.3	-	99.6
3	Биет бус хөрөнгө	2.5	2.1	0.4	86.4
3	Нийт зардал	310.6	303.2	7.4	95.5

Тайлант онд 310.6 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлын төсөв батлагдсан үүнээс 304.8 сая төгрөгийг урсгал зардалд, 5.8 сая төгрөгийг хөрөнгө худалдан авахад зориулж хуваарилсан байна. Гүйцэтгэлээр 303.2 сая төгрөгийг зарцуулж, 7.4 сая төгрөгийг хэмнэсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 888.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 886.9 сая төгрөгийн алдааг залруулж, 1.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

3. Санхүүгийн тайланд 40.0 мянган ам долларын өглөгийн дүнг тусгахдаа ханшийн тэгшитгэл хийгээгүй, 3.4 сая төгрөгийн валютын ханшны бодит бус алдагдлыг санхүүгийн тайланд тусгаагүй нь НББОУС21 23 дугаар зүйл "Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлийг хаалтын ханшаар тайлагнах ёстой" заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн Үнэн зөв байх, Хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ханшийн тэгшитгэл хийж санхүүгийн тайланг залруулсан

4. Нэг жилээс дээш хугацаатай 741в7 сая төгрөгийн толгой компаниас олгосон зээлийг богино хугацаат өглөгөөр санхүүгийн тайланд тусгасан нь Сангийн сайдын 249 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэл хөтлөх зааврын 2 дугаар бүлэгт "Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийн дүнг Урт хугацаат зээл хэсэгт толилуулна" гэж заасныг зөрчиж санхүүгийн тайлангийн Үнэн зөв байх, Хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

3. Санхүүгийн тайлангийн Урт хугацаат хөрөнгө оруулалт, бусад орлого зэрэг 141.8 сая төгрөгийг тодруулгад зохих ёсоор тодруулж тусгаагүй нь Сангийн сайдын 249 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэл хөтлөх зааврын Зургадугаар бүлэг Санхүүгийн тайлангийн тодруулгад " Охин компани хамтын хөрөнгө оруулалттай ААН, хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг НББОУС 27-ын дагуу тодруулна; Санхүүгийн тайлангийн тодруулгад орлогын бүрэлдхүүн тус бүрийн нийт болон цэвэр дүнг тодруулна" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн Үнэн зөв байх, Иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрдэнэс Метан ХХК-ийн Жейд Метан ХХК-тай хамтарч Метаны хийг олборлох, ашиглах зорилготойгоор шинээр байгуулсан хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж, олз гарзыг санхүүгийн тайланд тусгасан бүртгэлтэй танилцах нь зүйтэй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэс Метан ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Эрдэнэс Метан ХХК өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэс Метан ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрдэнэс Метан ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хуулийн дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг д сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг удирдлагад танилцуулж байна. Үүнд:

3.1 Ажилтнуудад илүү олгосон ээлжийн амралтын олговортой холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Ажилтнуудыг ажлын шаардлагын улмаас амрах боломжгүй байгаа үед нь нийт 1.7 сая төгрөгийн ээлжийн амралтын мөнгийг хий бодож тухайн сарын цалинтай нь цуг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д: “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно” мөн хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д “Ажилтанд ээлжийн амралтын хугацаанд ээлжийн амралтын олговор олгоно”, Эрүүл мэнд нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 2/717 тоот шийдвэрийн 2 дугаар заалт: “Ажилтны тухайн сард хөдөлмөрийн хөлс болон ээлжийн амралтын олговрыг нэг сард нэгтгэн олгосон олговор нь уг даатгуулагчийн хэддүгээр сард олгох хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого болохыг тодорхойлж харгалзах саруудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан (НД№7, НД№8)-д хамааруулж тайлагнана.” гэж заасныг тус тус зөрчиж Үнэн зөв байх, Иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна

3.1.2 Эрсдэл:

Цалин хөлсийг холбогдох заавар журмын дагуу тооцож олгоогүй байх, холбогдох заавар журмыг мөрдөж ажилаагүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цалин хөлсийг холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв тооцож олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Эйч Эл Би Аудит ХХК д 01/26 тоот албан бичгээр ирүүлсэн.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	12,851,063.98	768,038.34
1.1.2	Дансны авлага	503,662.00	535,233.95
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	178,823.38	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	1,424,081.06
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	1,112,682.00	0
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	956,270.97
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	14,646,231.36	3,683,624.32
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,351,204.46	8,700,779.95
1.2.2	Биет бус хөрөнгө	2,421,428.98	3,687,539.14
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	34,000,000.00	139,848,400.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.9		0.00	0.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	48,772,633.44	152,236,719.09
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	63,418,864.80	155,920,343.41
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	585,176,200.00	297,531,971.00
2.1.1.2	Цалингийн өглөг	191,667.09	42,450.70
2.1.1.3	Татварын өр	21,328.38	2,369,240.63
2.1.1.4	НДШ-ийн өглөг	20,272.14	29.50
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	156,569,890.07	130,478,235.40
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	0.00

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (Борлуулах бүлэг хөрөнгөд) хамаарах өр төлбөр	0.00	0.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	741,979,357.68	430,421,927.23
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	851,033,270.07
2.1.2.2	Нөөц /Өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.5		0.00	0.00
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	851,033,270.07
2.2	Өр төлбөрийн нийт дүн	741,979,357.68	1,281,455,197.30
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.2	Өмч-хувийн		
2.3.3	Өмч-хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	1,160,534,853.90	
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтын нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	34,000,000.00	34,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	713,560,492.88	-1,160,534,853.90
2.3.11	Эздийн өмчийн дүн	-678,560,492.88	-1,125,534,853.90
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	63,418,864.80	155,920,343.41

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	0.00	0.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	0.00	0.00
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	526,995.70	502,294.55
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	57,060.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	239,652,145.91	313,230,790.71
11	Санхүүгийн зардал	84,909,703.76	130,478,235.40
12	Бусад зардал	1,891,040.00	225,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	-3,492,400.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-325,868,833.97	-446,924,131.56
19	Орлогын татварын зардал	58,405.57	50,229.46
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-325,927,239.54	-446,974,361.02
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-325,927,239.54	-446,974,361.02
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-325,927,239.54	-446,974,361.02
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.0

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0.00	0.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	0.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-239,523,605.57	323,995,218.24
1.2.1	Ажиллагчдад төлсөн	103,936,176.15	111,732,693.40
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	27,446,467.98	31,840,524.99
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,674,282.00	5,549,171.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,575,000.00	806,664.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	11,007,237.35	9,897,789.07
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	90,884,442.09	164,168,375.78
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	106,590,148.60	-323,995,218.24
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	911,317.70	18,087,946.55
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	384,322.00	17,585,652.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	526,995.70	502,294.55
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8	Бусад мөнгөн орлого	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-8,942,991.00	4,382,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,782,991.00	2,700,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,160,000.00	1,682,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.2.6	Бусад мөнгөн зарлага	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,791,186.50	13,705,946.55
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	257,465,980.00	314,173,039.05

3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	257,465,980.00	314,173,039.05
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Бусад мөнгөн орлого	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.20	15,966,793.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0.00	15,966,793.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авхад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Бусад мөнгөн зарлага	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	257,465,980.00	298,206,246.05
4	Валютын ханшийн зөрүү	0.00	0.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	9,910,701.13	-12,083,025.64
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,940,362.85	12,851,063.98
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,851,063.98	768,038.34

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.0	34,000,000.00	-713,560,492.88	-678,560,492.88
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл		0.00	0.00	0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	0.0	0.00	0.00	0.00
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.00	0.00	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.00	0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.0	0.00	0.00	0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.00	0.00	0.00
9	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,000,000.0	34,000,000.00	-713,560,492.88	-678,560,492.88
10	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.0	0.00		
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.00	-446,974,361.02	-446,974,361.02
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.0	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.00	0.00	0.00
17	2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,000,000.0	34,000,000.0	-1,160,534,853.90	-1,125,534,853.90

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Эрдэнэс Метан” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020-03-09			САГ-2020/75/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Эрдэнэс Метан” ХХК		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажилтнуудыг ажлын шаардлагын улмаас амрах боломжгүй байгаа үед нь ээлжийн амралтын мөнгийг хий бодож тухайн сарын цалинтай нь цуг олгосон.	1.7	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Амар, Д.Саран
	Нийт	1.7			

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing a conclusion.